



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Мөнхсүндрэл ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/8/СТА-БСД

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг:
narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: В.Жавзмаа

Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	8
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл	10
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.9. Аудитын илрүүлэлт	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	11
Аудитын зөвлөмж	12
4. Менежментийн захидал	13

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 88
танай _____-ны № _____-т

МӨНХСҮНДРЭЛ ӨЭМТ-ИЙН
ДАРГА Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мөнхсүндрэл ӨЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мөнхсүндрэл ӨЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Мөнхсүндрэл ӨЭМТ-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт болон аймгийн Засаг дарга, ЭМГ-тай байгуулсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ", гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг 88.2 хувиар үнэлсэн бөгөөд эдгээр нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Авлага, өр төлбөрийг баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтын нормыг баталсан нормоор тооцоогүй, жолоочийн тооцооны хуудас, олгосон шатахууны тооцоог бодоогүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2-4 улирлын мэдээллийг огт мэдээлээгүй, байгууллагын дотоод журмыг өөрсдөд ашигтай байхаар хэлэлцэн баталж, 2019 онд төрийн одон медалиар шагнуулсан ажилтнуудад мөнгөн шагнал олгосон, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас гоо сайхны бүтээгдэхүүн, бусад зардлаас өрхийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн худалдан авч, зарцуулсан зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, аймгийн Засаг дарга, ЭМГ-тай байгуулсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ", Эрүүл мэндийн сайдын А/04 дугаар тушаалаар баталсан "Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм" зэрэг хууль эрх зүйн акт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцэхгүй, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.удит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгд	Эцсийн үлдэгд
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,109,485.09	17,172,637.72
МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,988.09	542,753.78
Кассанд байгаа бэлэн мөнгө	62,988.09	542,753.78
Касс арилжааны банк	62,988.09	542,753.78
АВЛАГА	30,400.00	93,098.44
Ажиллагчидтай холбогдсон авлага	30,400.00	93,098.44
БАРАА МАТЕРИАЛ	14,016,097.00	16,536,785.50
Түүхий эд материал	12,255,328.00	14,387,132.50
Тусгай зориулалттай материал	11,937,697.00	13,328,547.00
Эм боох материал	317,631.00	1,058,585.50
Хангамжийн материал	1,760,769.00	2,149,653.00
Бичиг хэргийн материал	431,600.00	640,484.00
Аж ахуйн материал	1,291,219.00	1,471,219.00
Бусад хангамжийн материал	37,950.00	37,950.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,423,413.91	90,414,246.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	41,423,413.91	90,414,246.00
Биет хөрөнгө	41,253,413.91	90,414,246.00
Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	22,777,777.79	26,097,778.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,446,772.00	135,699,372.00
Хуримтлагдсан элэгдэл	46,772,757.55	60,362,397.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,604,429.00	19,694,429.00
Хуримтлагдсан элэгдэл	12,358,288.00	13,519,380.00
Бусад үндсэн хөрөнгө	2,220,723.00	2,220,723.00
Хуримтлагдсан элэгдэл	2,109,686.75	2,220,723.00
Биет бус хөрөнгө	170,000.00	-
Програм хангамж	680,000.00	680,000.00
Хуримтлагдсан элэгдэл	510,000.00	680,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	55,532,899.00	107,586,883.72
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,679,429.66	805,444.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,679,429.66	805,444.00
Өглөг	1,679,429.66	805,444.00
Ажилчидтай холбогдсон өглөг	921,477.00	737,606.00
Бусад өглөг	757,952.66	67,838.00
Байгууллагад төлөх өглөг	757,952.66	67,838.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	53,853,469.34	106,781,439.72
Засгийн газрын хувь оролцоо	53,853,469.34	106,781,439.72
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	75,754,597.00	75,754,597.00
Хуримтлагдсан үр дүн	(23,208,810.66)	29,719,159.72
Өмнөх үеийн үр дүн	(12,820,697.73)	(24,549,167.02)
Тайлант үеийн үр дүн	(10,388,112.93)	54,268,326.74
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,307,683.00	1,307,683.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	55,532,899.00	107,586,883.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	231,236,011.66	382,358,861.75
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,641,000.00	60,200,826.52
Нийтлэг татварын бус орлого	1,641,000.00	200,826.52
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,221,000.00	200,826.52
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,221,000.00	200,826.52
Бусад орлого	420,000.00	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,595,011.66	322,158,035.23
Улсын төвлөрсөн төсвөөс	172,721,134.00	274,571,266.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	172,721,134.00	274,571,266.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	21,163,907.66	12,341,879.23
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,310,780.00	12,337,341.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,853,127.66	4,538.23
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,709,970.00	35,244,890.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,709,970.00	35,244,890.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	241,624,124.59	328,090,535.01
УРСГАЛ ЗАРДАЛ	241,624,124.59	328,090,535.01
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,497,722.59	301,522,440.01
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,169,199.00	202,474,493.00
Үндсэн цалин	151,169,199.00	202,474,493.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,900,462.94	11,229,225.58
Тэтгэврийн даатгал	12,663,930.96	7,145,870.82
Тэтгэмжийн даатгал	1,447,306.40	816,670.95
ҮОМШӨ-ний даатгал	1,809,132.99	1,020,838.69
Ажилгүйдлийн даатгал	361,826.60	204,167.74
Эрүүл мэндийн даатгал	3,618,265.99	2,041,677.38
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,069,955.86	5,687,485.36
Гэрэл, цахилгаан	1,250,354.02	1,145,868.96
Цэвэр, бохир ус	3,819,601.84	4,541,616.40
Хангамж, бараа материалын зардал	13,945,028.33	16,339,513.00
Бичиг хэрэг	4,660,134.00	1,040,352.00
Тээвэр, шатахуун	5,352,564.00	7,078,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	819,680.33	622,041.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	1,082,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	1,390,850.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	2,132,650.00	5,126,270.00
Нормативт зардал	21,615,501.51	34,295,935.92
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,355,182.51	29,517,384.92
Хоол, хүнс	2,029,319.00	3,402,051.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	231,000.00	1,376,500.00
Томилолт, зочны зардал	743,000.00	401,000.00
Дотоод албан томилолт	743,000.00	401,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,950,218.81	5,674,269.24
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,693,298.81	5,455,115.42
Тээврийн хэрэгслийн татвар	144,820.00	91,120.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,100.00	106,033.82
Бараа үйлчилгээний бусад зардал	12,104,356.14	25,420,517.91
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,005,000.00	7,068,750.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,099,356.14	18,351,767.91
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,126,402.00	26,568,095.00
Бусад урсгал шилжүүлэг	10,126,402.00	26,568,095.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,126,402.00	26,568,095.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(10,388,112.93)	54,268,326.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	247,449,071.66	328,442,022.23
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,023,126.00	-
Нийтлэг татварын бус орлого	13,023,126.00	-
Бусад орлого	13,023,126.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	234,425,945.66	328,442,022.23
Улсын төвлөрсөн төсвөөс	172,721,134.00	274,571,266.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	172,721,134.00	274,571,266.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	19,853,127.66	4,538.23
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,853,127.66	4,538.23
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,310,780.00	12,337,341.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,310,780.00	12,337,341.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	40,540,904.00	41,528,877.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,830,934.00	6,283,987.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,709,970.00	35,244,890.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	244,807,349.32	320,619,656.54
УРСГАЛ ЗАРДАЛ	244,807,349.32	320,619,656.54
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,000,513.52	287,767,574.54
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,278,122.00	184,722,750.00
Үндсэн цалин	150,278,122.00	184,722,750.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,900,462.94	11,229,225.58
Тэтгэврийн даатгал	12,663,930.96	7,145,870.82
Тэтгэмжийн даатгал	1,447,306.40	816,670.95
ҮОМШӨ-ний даатгал	1,809,132.99	1,020,838.69
Ажилгүйдлийн даатгал	361,826.60	204,167.74
Эрүүл мэндийн даатгал	3,618,265.99	2,041,677.38
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,069,955.86	6,216,216.30
Гэрэл, цахилгаан	1,250,354.02	1,107,697.96
Цэвэр, бохир ус	3,819,601.84	5,108,518.34
Хангамж, бараа материалын зардал	14,145,028.33	16,554,588.50
Бичиг хэрэг	4,860,134.00	1,249,236.00
Тээвэр, шатахуун	5,352,564.00	7,078,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	819,680.33	628,232.50
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	1,082,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	1,390,850.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	2,132,650.00	5,126,270.00
Нормативт зардал	19,666,520.51	35,096,590.42
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,406,201.51	30,138,039.42
Хоол, хүнс	2,029,319.00	3,402,051.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	231,000.00	1,556,500.00
Томилолт, зочны зардал	743,000.00	401,000.00
Дотоод албан томилолт	743,000.00	401,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,192,423.88	26,478,453.74
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,181,877.88	4,363,498.92
Тээврийн хэрэгслийн татвар	144,820.00	91,120.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,100.00	106,033.82
Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	12,753,626.00	21,895,801.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,005,000.00	7,068,750.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,005,000.00	7,068,750.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,806,835.80	32,852,082.00
Бусад урсгал шилжүүлэг	14,806,835.80	32,852,082.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,680,433.80	6,283,987.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,126,402.00	26,568,095.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,641,722.34	7,822,365.69
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,609,900.00	7,342,600.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,609,900.00	7,342,600.00
Дотоод эх үүсвэрээр	2,609,900.00	7,342,600.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,609,900.00	7,342,600.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,609,900.00)	(7,342,600.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,822.34	479,765.69
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,165.75	62,988.09
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,988.09	542,753.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	-23,208,810.66	53,853,469.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	-23,208,810.66	53,853,469.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	-23,208,810.66	53,853,469.34
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	-23,208,810.66	53,853,469.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1,340,356.36	-1,340,356.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	-24,549,167.02	52,513,112.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			54,268,326.74	54,268,326.74
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,754,597.00	1,307,683.00	29,719,159.72	106,781,439.72

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мөнхсүндэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Б.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль эрх зүйн баримтад нийцүүлэн шинэчлэх, дотоод хяналт хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Мөнхсүндэрэл ӨЭМТ нь 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэсэн статустай байна.

Мөнхсүндэрэл ӨЭМТ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг анхан шатны эмчилгээ, оношилгоо гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь 2020 онд “Эрүүл мэндийн төвийн үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд ээлтэй ,нээлттэй, хүртээмжтэй, чанартай, чирэгдэл хүлээгдэлгүй хүргэж, эрсдэлгүй орчин бий болгох” эрхэм зорилго дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл, мэнд нийгмийн даатгалын тухай хууль.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөнхсүндэрэл ӨЭМТөв нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй..

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн хэдий ч мөрдөж буй хууль, журам, дүрэм, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын СХАА-аас хяналт шалгалт хийгээгүй байна.

Мөнхсүндэрэл ӨЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд эрсдэлгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоосон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлого 149,887.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,489.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн суурь үзүүлэлтийг тайлант оны жилийн нийт орлого 382,358.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 3,823.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөнхсүндэрэл ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,053.9 мянган төгрөгөөр буюу 93.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	63.0	542.8	479.8
Авлага	30.4	93.1	62.7
Урьдчилгаа			
Бараа материал	14,016.1	16,536.8	2,520.7
Үндсэн хөрөнгө	41,423.4	90,414.2	48,990.8
Нийт хөрөнгийн дүн	55,532.9	107,586.9	52,054.0
Өр төлбөр	1,679.4	1,071.0	-608.4
Эздийн өмч	53,853.5	106,515.9	52,662.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	55,523.9	107,586.9	52,054.0

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 542.8 мянган төгрөг болж 479.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 93.1 мянган төгрөг болж 62.7 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн тооцооллоос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 16,536.8 мянган төгрөг болж 2,520.7 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотойгоор нэг удаагийн хэрэгслийн нөөц авснаас шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 49,940.9 мянган төгрөгийн, аймгийн ЭМГ-аас 120.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм боох материал хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 90,414.2 мянган төгрөг болж 48,990.8 мянган төгрөгөөр өссөн нь шинээр худалдан авсан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,071.0 мянган төгрөг болж 608.0 мянган төгрөгөөр буурсан нь ҮЭХ-ны болон ХХОАТ-ын тооцооноос шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 106,515.9 мянган төгрөг болж 52,662.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 75,754.6 мянган төгрөг бөгөөд өсөж, буураагүй байна.
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1,307.7 мянган төгрөг бөгөөд өсөж, буураагүй байна.

Хуримтлагдсан ашиг 29,719.1 мянган төгрөг болж 54,268.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийн тооцоог Эрүүл мэндийн яам статистик мэдээнд үндэслэн боловсруулдаг байна.

Төсвийн гүйцэтгэл

Аймгийн Эрүүл мэндийн газар нь төсвийн хуваарь батлаагүй бөгөөд Мөнхсүндрэл ӨЭМТ нь өөрийн баталсан хуваарийг хянуулж, батлуулаагүй байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 286,908.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 35,244.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4.5 мянган төгрөг, нийт 322,158.0 мянган төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн ӨЭМТ нь нэмэлт санхүүжилтийн данс ашигладаггүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 4 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 260,422.9 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,170.5	1	1,170.5	100
Албан шаардлага					
Зөвлөмж	3	1,710.0	3	1,710.0	100
Нийт дүн	4	2,880.5	4	2,880.5	

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 290,178.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23,236.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,497.5 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 264,374.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,071.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны зардалд бүртгэсэн байр ашиглалттай холбоотой 566.9 мянган төгрөгийн, холбооны зардал 35.8 мянган төгрөгийн, төлбөр хураамжийн зардал 737.6 мянган төгрөгийн, нийт 1,340.3 мянган төгрөгийн өр төлбөрийг зардлаар тайлагнасныг залруулав.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд нэр данс зөрүүтэйгээс үүссэн гүйлгээний 21,895.8 мянган төгрөгийг орлого, зарлагаар бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 266,942.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 264,374.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,497.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тайлант онд шатахуун зарцуулалтын нормыг баталсан нормоор тооцоогүй бөгөөд жолоочийн тооцооны хуудас, олгосон шатахууны тооцоог бодоход 55.8 мянган километр явахаас тооцоогоор баримттай тулгахад 18.2 мянган километр явж, 3,951.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулалтын баримтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тус өрхийн эрүүл мэндийн төв нь улирал бүр мэдээлэх улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 1 дүгээр улирлын мэдээллийг хугацаа хоцроож, 2-4 улирлын 260,422.9 мянган төгрөгийн мэдээллийг огт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван

сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй”, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-д “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэ журмын 19 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын дотоод журмыг өөрсдөд ашигтай байхаар хэлэлцэн баталж, 2019 онд төрийн одон медалиар шагнуулсан төвийн дарга, эмч нарт 720.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, аймгийн Засаг дарга, ЭМГ-тай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 6.1.8-д “Төсөв санхүүгийн холбогдолтой хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой зөв зарцуулж, хамт олон, иргэдэд мэдээлэх”, Эрүүл мэндийн сайдын А/04 дугаар тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д “төвд хуваарилагдаж буй санхүүжилтийг хугацаанд нь авч, зориулалтын дагуу захиран зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4. Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 112.9 мянган төгрөгийн гоо сайхны бүтээгдэхүүн, бусад зардлаас 319.6 мянган төгрөгийн өрхийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн, 345.0 мянган төгрөгийн автомашины тос, тосолгооны материал худалдан авч, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, аймгийн Засаг дарга, ЭМГ-тай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 6.1.8-д “Төсөв санхүүгийн холбогдолтой хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой зөв зарцуулж, хамт олон, иргэдэд мэдээлэх”, Эрүүл мэндийн сайдын А/04 дугаар тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д “төвд хуваарилагдаж буй санхүүжилтийг хугацаанд нь авч, зориулалтын дагуу захиран зарцуулах” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,071.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар зардлын дансыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн төсвийн хуваарь, гүйцэтгэл, дотоод хяналт хэрэгжүүлэх талаар тайланд тусгах саналтай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Оны эцэст тайлагнасан 1,071.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6 дугаар зүйлийн 3-т “Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байдал, үнэлгээ болон хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл: Бодитой оршин байх боломжгүй авлага, өр төлбөр бүртгэж тайлагнаснаар үргүй зардал өсөх, мэдээлэл хэрэглэгчийг алдаатай мэдээллээр хангах.

1.3 Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөнхсүндэрэл ӨЭМТ-ийн 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 10 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал асуудал

2.1 Илрүүлэлт: Аудитад ирүүлсэн баримт материалд үндсэн хөрөнгийн тооллогын баримтууд ирүүлээгүй бөгөөд ирүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан, туслах журналд жилийн эцсийн тооллогын талаарх мэдээлэл байхгүй, тооцоо хийж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Хөрөнгө эзэнгүйдэх, дутагдах, алдагдах, үргүй зардал өсөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тооцож байх.

Орхон аймгийн Мөнхсүндэрл өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөнхсүндэрл ӨЭМТ-ийн 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 10 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн дансанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Мөнхсүндэрл ӨЭМТ-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д "Бэлэн бусаар гарсан төлбөр тооцоонд дотоод хяналтыг дотоод хянагч, дарга, нягтлан бодогч нар хэрэгжүүлнэ. Дотоод хянагч нь уг тогтолцооны зорилго хэрхэн хангагдаж байгаа байдалд шинжилгээ хийж, тайлагнаж, зөвлөмж өгч ажиллана. Дотоод хянагчийн зүгээс ажилтнуудын ажил үүргийн зааг ялгаа, бэлэн бус төлбөр тооцоог зөвшөөрөх болон хянах горим, баримтжуулалт, бүртгэл хөтлөлт, тайлагналын чиглэлээр хяналтыг хэрэгжүүлнэ. Өрхийн эмнэлгийн дарга нь бэлэн бус төлбөр тооцооны баримтад нэгдүгээр гарын үсэг зурснаар зөвшөөрөл олгогдоно. Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн иж бүрэн байдалд хяналт тавих үүднээс дарга гарын үсэг зурсан төлбөрийн даалгавар, чек гэх зэрэг баримтуудаараа дэвтэр хөтөлж болно. Банкны данс дахь мөнгөн хөрөнгийг хянахдаа банкны хуулгыг үндэслэн сар бүр шалгаж, тооцоо нийлж, илэрсэн зөрүүний шалтгааныг тогтоож, зохистой арга хэмжээг авна. Өрхийн эмнэлгийн дарга илэрсэн зөрчлийг арилгах талаар шийдвэр гаргаж, түүнийг сэрэмжлүүлэх үүднээс ажилтан, албан тушаалтнуудад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Тус өрхийн эмнэлэг санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ийн программ хангамж ашигладаггүй ба НБББББ-ийг 2018 боловсруулсан баталсан хэдий ч мөрддөггүй байна.

2.2. Эрсдэл: Дотоод хяналт алдагдаж, үргүй зардал өсөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, журам дүрэмд нийцүүлэн шинэчлэн мөрдөж, дотоод хяналт хэрэгжүүлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөнхсүндэрл ӨЭМТ-ийн 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 10 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:


Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мөнхсүндэрл ӨЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/8/СТА-БСД
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Мөнхсүндэрл өрхийн эрүүл мэндийн төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд шатахуун зарцуулалтын нормыг баталсан нормоор тооцоогүй бөгөөд жолоочийн тооцооны хуудас, олгосон шатахууны тооцоог бодоход 55.8 мянган километр явахаас тооцоогоор баримттай тулгахад 18.2 мянган километр явж, 3,951.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулалтын баримтгүй зарцуулсан.	3,951.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
2	Улирал бүр мэдээлэх улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 1 дүгээр улирлын мэдээллийг хугацаа хоцроож, 2-4 улирлын 260,422.9 мянган төгрөгийн мэдээллийг огт мэдээлээгүй.	260,422.9	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
3	Байгууллагын дотоод журмыг өөрсдөд ашигтай байхаар хэлэлцэн баталж, 2019 онд төрийн одон медалиар шагнуулсан төвийн дарга, эмч нарт 720.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон.	720.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
4	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 112.9 мянган төгрөгийн гоо сайхны бүтээгдэхүүн, бусад зардлаас 319.6 мянган төгрөгийн өрхийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн, 345.0 мянган төгрөгийн автомашины тос, тосолгооны материал худалдан авч, зарцуулсан.	777.5	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
5	Оны эцэст тайлагнасан 1,071.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй.	1,071.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
6	Аудитад ирүүлсэн баримт материалд үндсэн хөрөнгийн тооллогын баримтууд ирүүлээгүй бөгөөд ирүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан, туслах журналд жилийн эцсийн тооллогын		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа

талаарх мэдээлэл байхгүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.				
--	--	--	--	--

Орхон аймгийн Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	талаарх мэдээлэл байхгүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.				
7	Тус өрхийн эмнэлэг санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ийн программ хангамж ашигладаггүй ба НБББББ-ийг 2018 боловсруулсан баталсан хэдий ч мөрддөггүй, мөнгөн хөрөнгийн дансанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Жаргалсайхан П.Сэрчмаа
ДҮН		266,942.7			

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Ахлах аудитор

В.ЖАВЗМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ

